

“Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох,  
тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах журам”-д  
оруулах нэмэлт, өөрчлөлт

Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах журам”-ын доор дурдсан заалтуудад өөрчлөлт оруулсугай.

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах журмын 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэг:

“4.6.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын том татвар төлөгч хариуцсан нэгж нь энэ журмын 4.2., 4.3., 4.4.-т заасны дагуу хянан шалгаж, баталгаажуулсан акт үйлдсэн болон буцаан олгох албан татварын хүсэлтийг шийдвэрлэснээс хойш ажлын 2 өдөрт багтаан татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь албан татвар буцаан олгуулах, бусад татварын өрөнд суутган тооцуулах эсэх саналаа энэ журмын 2, 3 дугаар хавсралтын дагуу гарган, холбогдох материалын хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”

2/ 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэг:

“4.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 4.6-д заасан санал хуульд заасан үндэслэл, шаардлагад нийцээгүй гэж үзвэл саналыг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногийн дотор дахин нягтлуулахаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэг удаа буцаан шийдвэрлэж болно.”

3/ 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэг:

“4.8.Энэ журмын 4.7-д заасны дагуу буцаан шийдвэрлэсэн саналыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хянан, шаардлагатай тохиолдолд ажлын 3 өдөрт багтаан актыг хэвээр хадгалах, эсхүл Татварын ерөнхий хуулийн 77.7.7-д заасан бүрэн эрхийн хүрээнд актыг өөрчлөн нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгуулах, бусад татварын өрөнд суутган тооцуулах саналаа холбогдох материалын хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”

4/ 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэг:

“4.9.Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг хянан баталгаажуулж, акт үйлдэхдээ дараах асуудлыг нягтлан үзсэн байна:

4.9.1.Илүү төлөлтөө анх удаа буцаан авах хүсэлт гаргасан албан татвар суутган төлөгчийн бүртгэл, бүртгэгдсэн хугацаа Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд шаардлагыг хангасан эсэх;

4.9.2.Харилцан хамааралтай этгээд хоорондын нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох ажил гүйлгээнд бодит бус үнэ хэрэглэсэн эсэх;

4.9.3.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан бусад шаардлага.”

2. Журмын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3, 4.4, 4.5 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.1.1 дэх заалтыг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

“4.1. Татварын алба энэ журмын 3.1-д заасан албан татвар суутган төлөгчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан албан татварын ногдол, төлөлтийн байдлыг нягталж, албан татварыг буцаан олгуулах саналыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын том татвар төлөгч хариуцсан нэгжид хүргүүлнэ.”

“4.2.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын том татвар төлөгч хариуцсан нэгж нь энэ журмын 4.1-д заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногт багтаан нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг хянан шалгаж, баталгаажуулсан акт үйлдэнэ.”

“4.3.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын том татвар төлөгч хариуцсан нэгж нь энэ журмын 3.2-т заасан дипломат төлөөлөгчийн болон консулын газрын хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногт багтаан хянаж, албан татварыг буцаан олгох, хянахаар шийдвэрлэсэн тухай бичгээр буюу цахим хэлбэрээр дипломат төлөөлөгчийн болон консулын газарт мэдэгдэнэ. Мэдэгдэлд буцаан олгох албан татварын хэмжээ, өөрчлөгдсөн болон хянах болсон үндэслэл зэргийг бичсэн байна.”

“4.4.Дипломат төлөөлөгчийн болон консулын газрын буцаан олголтыг хянахаар шийдвэрлэсэн бол энэ тухай мэдэгдсэнээс хойш ажлын 2 өдөрт багтаан шийдвэрлэнэ.”

“4.5. Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын том татвар төлөгч хариуцсан нэгж нь Татварын ерөнхий хуулийн 41.3-т заасны дагуу татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн эрсдэлгүй, бага эрсдэлтэй гэж тодорхойлогдсон бичил, жижиг ангилалд хамаарах албан татвар суутган төлөгчийн

нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан актыг хялбаршуулсан хяналт шалгалтаар үйлдэж болно.”

“5.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 4.4, 4.8-д заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 45 хоногт багтаан татвар төлөгчийн илүү төлөлтийг бусад татварын өрөнд суутган тооцох, буцаан олгох асуудлыг дараах журмаар шийдвэрлэнэ.”

“5.1.1.Төсвийн бодлого, төлөвлөлт хариуцсан нэгж нь саналыг хянаж, буцаан олголт хүссэн этгээдэд албан татвар буцаан олгох болон бусад татварын өрөнд суутган тооцох санхүүжилтийн эрхийг нээн, санхүүжилтийн мэдэгдлийг энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу бичиж, Төрийн сангийн нэгжид хүргүүлнэ;” гэж тус тус өөрчлөн найруулах.

--oo00oo--